



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: <a href="mailto:domogovi@audit.gov.mn">domogovi@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>
	Аудитор: Б.Алтанзул	
		Цахим хаяг: <a href="mailto:altanzulb@audit.gov.mn">altanzulb@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3.Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
4.Аудитын тайлан .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5.Аудитын илрүүлэлт .....	14
5.1 Зөвлөмж .....	15
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023.02.20 № 1-6/95

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ОЮУНБЯМБА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон бөгөөд тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,670.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр, 21.4 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдсэн байна. Холбогдох шийдвэрээр 18.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хассан байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" заалтыг зөрчин төсвийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Бичиг хэргийн зардал өмнөх оныхоос 89 хувиар өссөн, бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг 0.9 сая төгрөг буюу 38 ширхгээр илүү зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

010009404

## Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,110,488.80	122,962,113.60
33	АВЛАГА	15,653,481.70	21,380,845.70
335	Бусад авлага	15,653,481.70	21,380,845.70
3351	Байгууллагаас авах авлага	15,653,481.70	20,085,481.70
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,295,364.00
35	БАРАА МАТЕРИАЛ	120,457,007.10	101,581,267.90
351	Түүхий эд материал	39,353,500.00	6,287,500.00
35110	Тусгай зорцуулалттай материал	39,353,500.00	6,287,500.00
354	Хангамжийн материал	79,440,467.10	92,453,767.90
35410	Бичиг хэргийн материал	3,584,900.00	2,878,600.00
35420	Аж ахуйн материал	68,914,182.20	79,830,856.20
35430	Сэлбэг хэрэгсэл	6,941,384.90	9,744,311.70
35600	Мал амьтал	1,663,040.00	2,840,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,529,479,056.16	3,908,680,237.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,529,479,056.16	3,908,680,237.07
392	Биег хөрөнгө	2,394,846,881.08	3,774,785,262.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,128,139,740.57	2,714,075,900.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	127,486,638.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	345,471,300.00	343,722,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	184,866,826.52
39205	Машина тоног төхөөрөмж (компьютер)	197,796,699.18	192,137,678.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	87,990,873.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	226,046,374.50	212,678,238.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	136,312,943.33
39209	Зам, гүүрийн байгууламж	567,490,140.00	567,490,140.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	207,928,847.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	770,169,703.30	770,169,703.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	95,680,947.49
393	Биег бус хөрөнгө	134,632,175.08	133,894,975.00
39301	Програм хангамж	3,686,000.00	3,686,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	1,865,724.92
39303	Бусад биег бус хөрөнгө	132,811,900.00	132,811,900.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,665,589,544.96	4,031,642,350.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,363,382.00	10,707,830.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,363,382.00	10,707,830.00
413	Өглөг	11,363,382.00	10,707,830.00
41310	Ажилчилтай холбогдсон өглөг	-	139,976.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,363,382.00	10,567,854.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,654,226,162.96	4,020,934,520.67
51	Засгийн газрын хувь оролцоо	2,654,226,162.96	4,020,934,520.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,170,529,816.54	1,170,529,816.54
512	Хуримтлагдсан үр дүн	1,355,562,872.21	2,722,271,229.92
51210	Өмнөх үеийн үр дүн	1,355,562,872.21	1,355,562,872.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,366,708,357.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,133,474.21	128,133,474.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,665,589,544.96	4,031,642,350.67

4417144353  
E:OA0056 9025707

Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Давсмы код	Гуулалт	Өмнөх омы гүйцэтгэл	Тайлант омы гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (0)	859 999 142.00	2 137 568 259.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450 119 784.00	1 670 417 820.00
120	Нийтлэг татварын бус орлого	450 119 784.00	1 670 417 820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 158 850.00	2 130 689.00
1E-05	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжлэг	1 158 850.00	2 130 689.00
120009	Бусад орлого	-	43 451 171.00
120017	Үнэ төлбөргүй хүтэл авсан орлого-Үндэс хөрөнгө	331 192 724.00	1 603 485 960.00
12001	Үнэ төлбөргүй хүтэл авсан орлого-Баруу материал	117 768 210.00	21 350 000.00
13	ТҮСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409 879 388.00	467 160 439.56
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10 985 358.00	14 218 071.00
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчийн хувиарилсан хөрөнгө	2 000 000.00	3 091 000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8 985 358.00	11 127 071.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжлэг	398 894 000.00	452 932 368.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	398 894 000.00	452 932 368.56
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	645 385 921.11	735 992 912.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645 385 921.11	735 992 912.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЭГ ЭЭНИЙ ЗАРДАЛ	644 385 921.11	735 992 912.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252 832 693.00	285 989 956.00
210101	Үндсэн цалин	237 712 693.00	210 597 044.00
210102	Нэмэгдэл	-	30 379 217.00
210103	Умаа хоолны хөнгөлөлт	-	26 156 197.00
210104	Урамшуулал	-	13 039 807.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	15 120 000.00	5 817 691.00
210201	Тэтгэрийн даатгал	33 257 907.00	35 136 456.56
210202	Тэтгэмжийн даатгал	25 114 015.00	24 447 381.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 209 150.00	3 042 027.00
210204	Ажлын үндэсний даатгал	1 713 564.00	2 329 758.00
210205	Эрүүл мэндийн даатгал	383 685.00	646 433.00
2103	Байр ижиллэлтэй холбоотой тогтмол зардал	3 837 493.00	4 670 857.00
210301	Гэрэл, цахилгаан	51 597 733.00	55 377 395.00
210302	Тулш, халаалт	12 244 556.00	10 808 667.00
210303	Цэжэр, бохир үс	37 826 713.00	42 260 216.00
2104	Хялгамж, бараа материалын зардал	1 526 464.00	2 308 512.00
210401	Бичиг хэрэг	33 809 687.00	43 062 971.20
210402	Тээвэр, шатгалуучи	3 555 500.00	5 116 500.00
210403	Шүүдэл, холбоо, юстицийн төлбөр	17 003 042.00	25 039 756.00
210404	Ном, хэмлэл	3 699 835.00	3 679 166.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	230 800.00	284 200.00
210406	Бага үнэтэй, тургэн ашиглах, хуви эд зүйлс	240 000.00	240 000.00
210408	Бараа материал асгалсын зардал	9 080 510.00	2 844 160.00
2105	Нормативт зардал	-	5 859 189.20
210502	Хоол, дүкс	857 740.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	857 740.00	-
210604	Урсгал засвар	2 310 700.00	1 069 600.00
2107	Томлолт, зочны зардал	2 310 700.00	1 069 600.00
210702	Дотоон албан томлолт	2 237 522.00	4 416 200.00
2108	Бусад гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 237 522.00	4 416 200.00
210801	Бусад гүйцэтгүүлсэн бусад нийгэмж ажил үйлчилгээний төлбөр хураамж	18 653 774.00	33 495 333.00
210803	Дагталын үйлчилгээ	16 914 134.00	31 666 675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	792 450.00	753 075.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	341 108.00	321 308.00
210806	Тээврийн хэрэгслийн оношлогоо	275 000.00	300 000.00
210807	Газрын төлбөр	331 082.00	454 275.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	248 828 165.11	277 445 000.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2 312 000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн далага хийх	-	80 000.00
210903	Үндсэн хөрөнгийн мэтгэл, хорголт	248 828 165.11	275 053 000.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 000 000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 000 000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 000 000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	214 613 220.89	1 401 575 347.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	101 161 600.00	34 866 989.81
225001	Үндсэн хөрөнгө худалдсан гарз	24 350 000.00	137 949.81
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	75 811 600.00	34 729 040.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	34 866 989.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	113 451 620.89	1 436 442 337.33

4417144353  
ЕЮА0056 9025707

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Давсмы код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	584,543,694.70	483,175,746.26
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	1,158,850.00	371,825.00
120	Нийтлэг татварын бүс орлого	1,158,850.00	371,825.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,158,850.00	371,825.00
1E-06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжилт	1,158,850.00	371,825.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,384,844.70	482,803,921.26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	184,490,844.70	29,871,552.70
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарилсан хөрөнгө	2,000,000.00	3,091,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны гүрээнд бий болсон нэмэлт	182,490,844.70	26,780,552.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжилт	398,894,000.00	452,932,368.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	398,894,000.00	452,932,368.56
2	НИЙТ ЗАРДАГА БА ЦЭВЭР ЭЗЭЛЛИЙН ДҮН (2)	574,721,794.70	475,720,746.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,721,794.70	475,720,746.26
210	БАРАА, АЖЛЛ ҮЙЛЧЛЭГ ЭЭНИЙН ЗАРДАЛ	567,768,313.00	456,781,264.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,832,693.00	285,923,539.00
210101	Үндсэн цалин	237,712,693.00	210,530,627.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унал хоолны хөнгөлөлт	-	30,379,217.00
210104	Урамшуулал	-	26,156,197.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	13,039,807.00
2102	Ажлал олгогчоос ийнгийн давталт төлөх шийтгэл	15,120,000.00	5,817,691.00
210201	Тэтгэрийн давталт	33,257,907.00	35,062,897.56
210202	Тэтгэмжийн давталт	23,472,120.00	24,373,923.56
210203	ҮОАШӨ-ний давталт	2,607,215.00	2,860,817.00
210204	Ажигчид өдийн давталт	2,022,383.00	2,283,895.00
210205	Эрүүл мэндийн давталт	452,262.00	504,034.00
2103	Байр өмчлөлттэй холбоотой тогтмол зардал	4,703,927.00	5,040,227.00
210301	Гэрэл, хангамж	50,802,205.00	56,188,923.00
210302	Тулш, халаалт	12,244,556.00	10,808,667.00
210303	Цэвэр, бохир ус	37,826,713.00	42,260,216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	730,936.00	3,120,040.00
210401	Бичиг хэрэг	21,339,777.00	24,322,192.00
210402	Тээвэр, шатаах	4,508,900.00	3,263,400.00
210403	Шуудан, холбоо, юттерингийн төлбөр	9,947,542.00	14,275,436.00
210404	Ном, хэргэл	3,730,835.00	4,036,166.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал	280,800.00	284,200.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, хэвн эд гүйлс	240,000.00	240,000.00
2105	Нормативт зардал	2,631,700.00	2,222,990.00
210503	Нормын хувьд, зөөлөн эдлэл	441,800.00	-
2106	Эл хогшил, урсгал засварын зардал	441,800.00	-
210604	Урсгал засвар	5,200,700.00	4,620,300.00
2107	Томьлолт, зочны зардал	5,200,700.00	4,620,300.00
210702	Дотоод албан томьлолт	1,583,522.00	4,416,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,583,522.00	4,416,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ийнлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	192,308,199.00	40,137,213.00
210803	Давтгалын үйлчилгээ	190,568,559.00	38,308,555.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	792,450.00	753,075.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	341,108.00	321,308.00
210807	Газрын төлбөр	275,000.00	300,000.00
2109	Бариа үйлчилгээний бусад зардал	331,082.00	454,275.00
210901	Бариа үйлчилгээний бусад зардал	1,510.00	5,080,000.00
210902	Хөгжил үйлдвэрлэлийн налаага хийс	1,510.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛДЭҮҮЛЭГ	-	80,000.00
2132	Бусад урсгал шилдүүлэг	16,963,481.70	19,969,481.70
213209	Нэг удамгийн тэтгэмж, шалгал урамшуулал	1,300,000.00	347,500.00
2134	Орон нутгийн төсвийн өрөөнийг захирагчид олгох татаас, санхүүжилт	1,300,000.00	347,500.00
213405	Нэмэлт санхүүжилтийн татан төшлөрүүлэлт	15,653,481.70	19,621,981.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)-(1)-(2)	9,821,900.00	7,455,000.00
3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (3)	9,821,900.00	7,455,000.00
22	ХӨРӨНГӨНИЙН ЗАРДАЛ	9,821,900.00	7,455,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,821,900.00	7,455,000.00
225106	Биег ба биег бүс хөрөнгө худалдаа авсан зардал	9,821,900.00	7,455,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)-(4)-(5)	9,821,900.00	7,455,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)-(3)-(6)-(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

4417144351  
EHOA0056 902570

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээх үзлэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үзлэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээх үзлэгдэл	-	-	-	-
D01	2022 оны 1-р сарын 1-нээх үзлэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	1,355,562,872.21	2,654,226,162.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үзлэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Галаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,366,708,357.11	1,366,708,357.71
D09	2022 оны 12-р сарын 31-нээх үзлэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,722,871,229.92	4,020,934,520.67

43774333  
E-C:4058 9025787

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эхний засгийн ангилал	Үгүүлэл	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү гүйц
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛЛИН ДҮН			
21	УРСГАЛ ЗАРДАЛ	559,073,400.00	453,304,193.56	105,769,206.44
210	БАРАА, АЖЛЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,073,400.00	445,849,193.56	113,224,206.44
2101	Цалин хэмж бэлэн нэмэгдэл урамжилт	554,573,400.00	445,501,693.56	109,071,706.44
210101	Үндсэн цалин	327,816,600.00	285,923,539.00	41,893,061.00
210102	Нэмэгдэл	234,446,600.00	210,530,627.00	23,915,973.00
210103	Улма хоолом хөнгөлөлт	33,044,000.00	30,379,217.00	2,664,783.00
210104	Урамшуулал	31,760,000.00	26,156,197.00	5,543,803.00
210105	Гэрээт ажлын хэсэг	21,904,000.00	13,039,807.00	8,864,193.00
2102	Ажлын өргөгчөөс нийгмийн даатгалд төлөх нэмэгдэл	6,720,000.00	5,817,691.00	902,309.00
210201	Тэтгэврийн даатгал	38,418,800.00	35,062,897.56	3,355,902.44
210202	Тэтгэврийн даатгал	25,306,100.00	24,373,923.56	932,176.44
210203	ҮОМШӨ-ийн даатгал	3,278,200.00	2,860,817.00	417,383.00
210204	Ажлын үйлчилгээний даатгал	2,622,400.00	2,283,896.00	338,504.00
210205	Эрүүл мэндийн даатгал	655,800.00	504,034.00	151,766.00
2103	Байр ашиглалттай халбаатой төгтмөл зардал	6,556,300.00	5,040,227.00	1,516,073.00
210301	Гэрм, цохионон	69,562,200.00	56,188,923.00	13,373,277.00
210302	Түшиг, хилант	21,848,700.00	10,808,667.00	11,040,033.00
210303	Цэвэр, бохир ус	44,683,000.00	42,260,216.00	2,422,784.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,030,500.00	3,120,040.00	-89,540.00
210401	Бичиг хэрэг	29,551,300.00	23,369,296.00	6,182,004.00
210402	Тээвэр, шатхуун	4,400,400.00	3,263,400.00	1,137,000.00
210403	Шуудан, хамбоо, интернетын төлбөр	17,654,400.00	13,352,540.00	4,301,860.00
210404	Нөм, хэвцэн	4,256,500.00	4,006,166.00	250,334.00
210405	Хөгжлийн зайнуулалт, хортон зэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	284,200.00	15,800.00
210406	Бага үнэтэй, түргэн илгидэг, агуулиг зүйлс	240,000.00	240,000.00	-
2106	Нормативт зардал	2,700,000.00	2,222,990.00	477,010.00
210603	Нормативт зардал	2,000,000.00	-	2,000,000.00
210604	Эл хөнгөлөлт, урсгал засварын зардал	2,000,000.00	-	2,000,000.00
210601	Батал, төлөх, хэргийн	31,580,000.00	4,620,300.00	26,959,700.00
210602	Төрийн	15,000,000.00	-	15,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	-	10,000,000.00
2107	Төрийн зардал	6,580,000.00	4,620,300.00	1,959,700.00
210702	Дотоод албан томилолт	5,376,500.00	4,216,200.00	1,160,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын үйлчилгээний төлбөр, хураамж	5,376,500.00	4,216,200.00	1,160,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийгэм ажлын үйлчилгээний төлбөр	43,768,000.00	31,040,538.00	12,727,462.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	40,000,000.00	29,211,880.00	10,788,120.00
210803	Давтгалын үйлчилгээ	576,000.00	-	576,000.00
210804	Төрийн хэрэгсэлийн татвар	800,000.00	753,075.00	46,925.00
210805	Төрийн хэрэгсэлийн өмчлөлөгөө	812,000.00	321,308.00	490,692.00
210807	Газрын төлбөр	300,000.00	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,000.00	454,275.00	825,725.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00	5,080,000.00	1,420,000.00
210902	Хөгжлийн үйлчилгээний дэмжлэг хийх	5,000,000.00	5,000,000.00	-
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	80,000.00	1,420,000.00
21132	Бусад урсгал шилжүүлэг	4,500,000.00	347,500.00	4,152,500.00
213209	Им үзвэрийн тэтгэсэг, шагнаа урамшуулал	4,500,000.00	347,500.00	4,152,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
2200	Дотоод эх үүсвэрээр		7,455,000.00	-7,455,000.00
225106	Бичиг ба бичиг бүх хэрэгээр		7,455,000.00	-7,455,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	559,073,400.00	453,304,193.56	105,769,206.44
132001	Орон нутгийн төсвөөс	558,073,400.00	452,932,368.56	105,141,031.44
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	371,825.00	628,175.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	1,000,000.00	371,825.00	628,175.00

4417144353  
EUDA0056 9025707

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>29,871,552.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,871,552.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,249,571.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	952,896.00
210402	Тээвэр, шатахууц	922,896.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2107	Томилголт, зочны зардал	200,000.00
210702	Дотоод албан томилголт	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,096,675.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,096,675.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,621,981.70</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,621,981.70
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	19,621,981.70
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,871,552.70</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,871,552.70</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,091,000.00
131105	Төсвийн байгууллагын үлдсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,780,552.70
	Мөнгө, гүүцтэй ашигтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, гүүцтэй ашигтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

**3. Санхүүгийн тайлангийн тодруулга**

4417144353  
БНДА0056 9025707

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх.

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх, мэдлэг чадварт суурилсан, идэвх санаачилгатай чадварлаг албан хаагч бүхий төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ.

Байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт:

- Гэр бүлийн боловсролыг дэмжих жил

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд сумын Засаг даргын захирамжаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,366.0 сая төгрөгөөр буюу 51.2 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт** /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	15,653.5	21,380.8	5,727.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	120,457.0	101,581.3	-18,875.7
Үндсэн хөрөнгө	2,529,479.1	3,908,680.2	1,379,201.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,665,589.5</b>	<b>4,031,642.4</b>	<b>1,366,052.9</b>
Өр төлбөр	11,363.4	10,707.8	-655.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,654,226.2	4,020,934.5	1,366,708.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,665,589.5</b>	<b>4,031,642.4</b>	<b>1,366,052.9</b>

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101.6 сая төгрөг болж 18.9 сая төгрөгөөр буурсан байна. Тодруулбал: Тодруулбал: Ковид-19 цар тахлын үед хандиваар ирсэн шинжилгээний тестийг эрүүл мэндийн төвд шилжүүлэн данснаас хассан шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,908.7 сая төгрөг болж 1,379.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгасан, мөн Мак Цемент ХХК, Говийн Шандаст Хүлэг ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд гүйцэтгэсэн барилга болон тавилга эд хогшлыг дансанд бүртгэн авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,020.9 сая төгрөг болж 1,366.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,277.6 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 90.6 сая төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 558.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөг, нийт зарлагыг 559.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардлыг 13.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 17.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардлыг 3.2 сая төгрөг, эд

хогшил урсгал засварын зардлыг 4.3 сая төгрөгөөр бууруулж 559.1 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 559.2 төгрөгийн төсөв баталснаас 558.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 1.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 452.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлого 0.3 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 453.3 сая төгрөг буюу 81.1 хувьтай байгаа нь цалин хөлс 41.9 сая төгрөг, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 3.4 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13.4 сая төгрөг, хангамж материалын зардал 6.2 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 27.0 сая төгрөг, томилолт зочны зардал 1.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардал 12.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<i>70106 – Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</i>					
1	Үндсэн үйл ажиллагаа	429,466.30	352,390.20	77,076.10	82.05%
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7,560.00	6,657.70	902.30	88.06%
3	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	72,547.10	59,696.90	12,850.20	82.29%
4	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,000.00	819.00	181.00	81.90%
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,500.00	347.50	4,152.50	7.72%
6	Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.00	19,597.60	10,402.40	65.33%
7	Хур хог хаягдал, орчны бохирдол	9,000.00	8,795.20	204.80	97.72%
8	Улсын их баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.00%
	<b>Нийт дүн</b>	<b>559,073.40</b>	<b>453,304.10</b>	<b>105,769.30</b>	<b>81.08%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26.8 сая төгрөг, нийт 29.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: тээвэр шатахуун 0.9 сая, шуудан холбоо 0.03 сая, дотоод албан томилолт 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээ 9.1 сая нийт 10.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 19.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төрийн хэмнэлтийн тухай холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 645.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 154.4 сая төгрөгийн 8 орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй

байна. Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 27.8 сая төгрөгийн 12 шийдвэрийг хугацаандаа үнэн зөв байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 8 эрсдэлийг тодорхойлж, горим сорил хэрэгжүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Хэрэгжүүлсэн тайланг нотлох баримтаар баталгаажуулан ирүүлсэн болно.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	385.2	1	385.2	100
Албан шаардлага	5	44,600.0	5	44,600.0	100
Зөвлөмж	4	740.5	4	740.5	100
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>45,725.7</b>	<b>10</b>	<b>45,725.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 0.7 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Цалингийн өглөгийг 0.4 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.
2. Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 0.3 сая төгрөгийг авлагаар бүртгэж залруулав.

Аудитаар нийт 3.1 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1.6 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч, малчдыг урамшуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Өглөгийн тайлангийн тээвэр шатахуун, урсгал засвар, бусад зардлын өглөг болох 11.8 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлын тайлант жилийн гүйцэтгэлийг шалгахад бичгийн цаас 38 ширхгийг буюу 0.9 сая төгрөгөөр, хэвлэгчийн хор 0.4 сая төгрөгөөр нийт 1.3 сая төгрөгөөр /40 ширхэг/ өмнөх оны гүйцэтгэлээс хэтрүүлэн зарцуулсан нь хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэх үр дагавартай байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, тус хуулийн 4 дүгээр зүйлд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг баримтлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

### 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ээлжийн амралтын олговор олгосон 1 албан хаагчийн 8-р сарын цалин бодолтыг хийгээгүйгээс тухайн сарын даатгуулагчаас болон, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, нийт 0.2 сая төгрөгийн суутгалыг тайлагнаагүй, хуульд заасан хугацаанд төлөөгүй байгаа нь зардал буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх үр дагавартай байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “ажил олгогч хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасаж тооцсон дүнгээс хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, 27.1-д “Суутган төлөгч татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан хаагчийн цалингаас суутгасан даатгуулагчаас болон, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвар нийт 0.2 сая төгрөгийн суутгалыг холбогдох тайланд нөхөн тайлагнаж, шимтгэлийг холбогдох төсөвт төлөх, цаашид Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

### 3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийгдсэн 1.9 сая төгрөгийн 8 зардлын гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр /и-баримтын системд бүртгүүлээгүй/ хийсэн байгаа нь татварын орлого буруу тайлагнагдах эрсдэл үүсэх үр дагавартай байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллаж, зарлагын гүйлгээг төлбөрийн баримтаар баталгаажуулан хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг дутуу үүсгэсэн	1	423.7	1	423.7	-	-	1	423.7	-	-	-	-
Авлагыг дутуу үүсгэсэн	1	240.0	1	240.0	-	-	1	240.0	-	-	-	-
Дүн	2	663.7	2	663.7	-	-	2	663.7	-	-	-	-

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй	1	1,581.0	-	-	1	1,581.0					-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй	1	1,311.2					1	1,311.2				
Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	0			1	0						
Цалингийн суутгалыг тайлагнаагүй, төсөвт төлөөгүй	1	211.3					1	211.3				
Худалдан авалтыг төлбөрийн	1	0					1	0				

баримтаар баталгаажуулаагүй										
Дүн	5	3,103.5			2	1,581.0	3	1,522.5	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								